МУХАУТ

7 ХОНОГИЙН ТОЙМ

2026.04.20 – 2026.04.24 | МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ | Дугаар / 26.04

БУСАД НҮҮРЭНД

Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа

Гадаад худалдааны салбарын ээлжит мэргэжилтнүүд төгсөлтөө хийлээ

"Дэлхийн Лабораторийн өдөр 2026" салбарын хөгжил, хамтын ажиллагааг онцолж байна

Геополитикийн өөрчлөлт ба Гадаад худалдааны шинэ боломжуудыг хэлэлцлээ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх замаар хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлнэ

Монгол, Хятадын Арбитрын байгууллагууд хамтын ажиллагаагаа өргөжүүллээ

Монгол–Казахстаны эдийн засгийн харилцаа шинэ шатанд: Астана дахь Бизнес Форумын онцлох үйл явдлууд

Бизнес форум ба үзэсгэлэнгүүд

7 ХОНОГИЙН ТОЙМ

Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа

Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарансүх нар аж ахуйн нэгж, байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдлэг, соёлыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллахаар санамж бичигт гарын үсэг зурлаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх замаар хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлнэ

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум – 2026"-г нээж хэлсэн үгэндээ тус танхим ТХХТ-ийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд бизнес эрхлэгчдийн саналыг тусган идэвхтэй ажиллаж ирснийг тэмдэглээд, хөрөнгө оруулалтыг дэмжихэд төрөөс баримтлах тогтвортой бодлого, ил тод байдал болон эрсдэлийн зөв хуваарилалт нэн чухал болохыг онцлов.

Монгол, Хятадын Арбитрын байгууллагууд хамтын ажиллагаагаа өргөжүүллээ

Монголын Олон Улсын Арбитрын дарга С.Энхцэцэг БНХАУ-ын Бээжин, Си Ан хотын Арбитрын комисс болон "Zhonglun W&D" хуулийн фирмийн төлөөлөгчидтэй уулзаж, байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулахын зэрэгцээ бүс нутгийн түншлэл, интеграцийг бэхжүүлэх хамтын ажиллагааны боломжуудын талаар санал солилцлоо.

Гадаад худалдааны салбарын ээлжит мэргэжилтнүүд төгсөлтөө хийлээ

МҮХАҮТ-ын Бизнес академиас 1994 оноос хойш тасралтгүй 32 дахь жилдээ зохион байгуулж, өнөөдрийг хүртэл нийт 1146 мэргэжилтнийг бэлтгэсэн "Гадаад худалдааны менежер" мэргэшүүлэх сургалтын ээлжит төгсөлт болж, Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны салбарт мэргэшсэн боловсон хүчний эгнээг дахин нэг төгсөлтөөр тэллээ.

Геополитикийн өөрчлөлт ба Гадаад худалдааны шинэ боломжуудыг хэлэлцлээ

МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар 40 гаруй бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон "Өглөөний цай" уулзалтыг модераторлон зохион байгуулж, зочноор уригдсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Энхбаяр геополитикийн нөхцөл байдал Монгол Улсын эдийн засаг, олон улсын худалдаанд хэрхэн нөлөөлж буй талаар илтгэл тавьж, санал солилцлоо.

"ДЭЛХИЙН ЛАБОРАТОРИЙН ӨДӨР 2026" салбарын хөгжил, хамтын ажиллагааг онцолж байна

МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар "Дэлхийн лабораторийн өдөр 2026" арга хэмжээний нээлтийн үеэр лабораторийн салбар нь экспорт, импортын аюулгүй байдлын суурь дэд бүтэц болохыг онцолж, салбарын хөгжилд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон хүний нөөцийн чадавх чухал үүрэгтэйг тэмдэглэлээ.

7 ХОНОГИЙН ТОЙМ

Монгол–Казахстаны Эдийн засгийн харилцаа шинэ шатанд: Астана дахь Бизнес Форумын онцлох үйл явдлууд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Казахстан улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд Астана хотноо зохион байгуулагдсан "Монгол–Казахстаны бизнес форум"–д МҮХАҮТ–ын Ерөнхийлөгч Б.Лхагважаваар ахлуулсан Монголын 90 гаруй аж ахуйн нэгжийн 100 гаруй төлөөлөгч, Казахстаны 150 гаруй бизнес эрхлэгчид оролцож, барилга, хөдөө аж ахуй, инновац, эмэгтэйчүүдийн манлайллын салбарт туршлага судлан, хамтын ажиллагааны олон чухал хэлцэл, санамж бичгүүдийг байгууллаа.



БИЗНЕС ФОРУМ БА ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

1. Шанхай руу тоног төхөөрөмжийн туршлага судлах аялал / 2026.05.12 – 05.16/ МҮХАҮТ–ын гишүүн байгууллагуудыг Шанхай хотын сэргээгдэх эрчим хүч, ногоон технологи, хүнс болон сүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч нартай танилцах, туршлага судлах, B2B уулзалт хийх бизнес аялалд урьж байна.

2. "Bazaar Berlin 2026" /11.04–08/: ХБНГУ–ын Берлин хотноо болох дэлхийн соёл, гар урлалын үзэсгэлэнд оролцохыг урьж байна.

3. KIDS EXPO 2026 эх, үрсийн баярт зориулсан үзэсгэлэнд оролцогчдын бүртгэл явагдаж байна /2026.05.29–06.01/

4. "ENVEX 2026" ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНД УРЬЖ БАЙНА /2026.05.19 – 05.23/

Байгаль орчны технологи, ногоон эрчим хүчний салбарын хамгийн том цугларалт

"ENVEX 2026" 47 дахь удаагийн үзэсгэлэн Сеул хотноо зохион байгуулагдах гэж байна.

5. "Монгол–Чехийн бизнес уулзалт, аялал" /2026.05.12–20/ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо "Монгол–Чехийн бизнес уулзалт, аялал" арга хэмжээг зохион байгуулна.

ҮЗЭСГЭЛЭНГИЙН СТЭНД, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

+(976) 7727–7070/4/,
exhibition@mongolchamber.mn.